



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/ЗНБ

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Байгалийн орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт (Булган сум)-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 2-р багц "Амралт чөлөөт цагийн талбай Б хэсэг"-ийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "МГБИ" ХХК-тай 448,092,277 (дөрвөн зуун дөчин найман сая ерэн хоёр мянга хоёр зуун далан долоо) төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "МГБИ" ХХК-ийн захирал (Л.Баттүвшин) нарт даалгасугай.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010447

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 15 ны/ний өдрийн /346 дугаар
захирамжийн хавсралт



д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	7,433,448	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	7,433,448	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	3,716,724	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	669,010	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	20,000,000	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
8	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн